**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Баянхонгор аймгийн Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2026/128/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2026 оны 01 дүгээр сарын 30 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Алтантуяа<br>Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Аудитор: Н.Бүнчинсүрэн<br>Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсандданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2026.02.04 № 2/02

танай__________-ны № __________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Б.УНДАРМАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Галуут сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/06 дугаар тушаалаар баталсан "Анхан шатны амбулаторийн шүдний тусламж

6426050004

үйлчилгээ үзүүлэх журам"-ыг Төсвийн тухай хуульд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2025 онд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 1,450,363.4 мянга, орон нутгийн төсвөөс 80,197.2 мянга, өөрийн орлогоос 7,645.4 мянга, нийт 1,538,205.9 мянган төгрөгийн төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,462,979.6 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 4,860.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 92.5 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

3

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **228,532,263.70** | **108,709,598.83** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 760,500.00 | 71,126,533.42 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 760,500.00 | 71,126,533.42 |
| **3121** | **Төгрөг** | 760,500.00 | 71,126,533.42 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 760,500.00 | 71,126,533.42 |
| **33** | **АВЛАГА** | 208,582,717.25 | 5,225,140.63 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 15,425.84 | 00.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 208,567,291.41 | 5,225,140.63 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 19,189,046.45 | 32,357,924.78 |
| **351** | **Түүхий эд материал** | 2,113,854.00 | 13,305,434.51 |
| 35130 | Эм боох материал | 2,113,854.00 | 13,305,434.51 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | 5,000,000.00 | 00.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 12,075,192.45 | 19,052,490.27 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 518,500.00 | 518,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 11,556,692.45 | 18,533,990.27 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,471,069,895.63** | **1,384,279,060.21** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,471,069,895.63 | 1,384,279,060.21 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,427,611,895.63 | 1,340,821,060.21 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,211,911,487.01 | 1,241,363,067.89 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -174,501,677.87 | -200,432,893.51 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 189,042,000.00 | 189,042,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -15,907,516.82 | -35,373,716.90 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 409,285,307.52 | 298,045,521.79 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -246,427,651.35 | -193,675,785.65 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 87,333,250.00 | 79,881,250.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -39,769,476.98 | -44,474,024.21 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 9,032,000.00 | 8,032,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -2,385,825.88 | -1,586,359.20 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 43,458,000.00 | 43,458,000.00 |
| 39301 | Програм хангамж | 450,000.00 | 450,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -450,000.00 | -450,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 43,458,000.00 | 43,458,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,699,602,159.33** | **1,492,988,659.04** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **18,746,980.65** | **3,870,380.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 18,746,980.65 | 3,870,380.00 |
| **413** | **Өглөг** | 18,746,980.65 | 3,870,380.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 3,870,380.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 18,746,980.65 | 00.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 18,746,980.65 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,680,855,178.68** | **1,489,118,279.04** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,680,855,178.68 | 1,489,118,279.04 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 247,732,382.97 | 247,732,382.97 |
| 51101 | Өмч: - төрийн | 247,732,382.97 | 247,732,382.97 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 781,785,435.76 | 590,048,536.12 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 781,785,435.76 | 782,235,435.76 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -192,186,899.64 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 651,337,359.95 | 651,337,359.95 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,699,602,159.33** | **1,492,988,659.04** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,890,450,529.03** | **1,377,378,502.66** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **585,034,625.08** | **50,160,086.26** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 585,034,625.08 | 50,160,086.26 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 39,487,000.00 | 7,645,388.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 39,487,000.00 | 7,645,388.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,305,415,903.95** | **1,327,218,416.40** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 57,367,300.00 | 80,197,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 57,367,300.00 | 80,197,200.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,248,048,603.95 | 1,247,021,216.40 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,248,048,603.95 | 1,247,021,216.40 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,353,969,513.86** | 1,569,565,402.30 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,353,969,513.86** | 1,569,565,402.30 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,351,578,164.86 | 1,564,705,120.24 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 754,669,585.62 | 902,510,959.84 |
| 210101 | Үндсэн цалин | 443,544,793.62 | 483,588,419.84 |
| 210102 | Нэмэгдэл | 251,895,462.00 | 329,443,990.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,660,000.00 | 28,980,000.00 |
| 210104 | Урамшуулал | 53,569,330.00 | 60,498,550.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 94,831,969.93 | 114,745,155.51 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 64,123,815.39 | 77,641,225.91 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,660,317.53 | 9,002,003.84 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,394,778.55 | 5,388,867.53 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,736,212.36 | 4,509,756.46 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,916,846.10 | 18,203,301.77 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 53,475,951.00 | 66,186,462.94 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,308,111.00 | 6,085,352.94 |
| 210302 | Түлш, халаалт | 49,167,840.00 | 60,101,110.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 139,112,212.63 | 107,922,379.04 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,187,750.00 | 9,119,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 38,281,337.00 | 39,754,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,138,100.00 | 2,343,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 44,893,561.08 | 35,882,220.02 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,346,200.00 | 4,955,100.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 37,265,264.55 | 15,868,059.02 |
| **2105** | **Нормативт зардал** | 150,832,716.00 | 167,755,946.49 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 125,973,486.00 | 141,852,396.49 |
| 210502 | Хоол, хүнс | 15,961,730.00 | 21,903,550.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 8,897,500.00 | 4,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,098,000.00 | 26,707,535.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,625,000.00 | 1,545,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 4,101,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,473,000.00 | 21,061,235.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,800,600.00 | 2,810,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,800,600.00 | 2,810,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,816,579.00 | 9,246,392.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 5,000,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,000,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 209,475.00 | 2,914,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 37,100.00 | 1,235,192.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 473,000.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 97,004.00 | 97,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 140,940,550.68 | 166,820,289.42 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,117,380.00 | 24,270,454.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 128,823,170.68 | 142,549,835.42 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,391,349.00 | 4,860,282.06 |

| | | | |
|---|---|---|---|
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 2,391,349.00 | 4,860,282.06 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,391,349.00 | 4,860,282.06 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **536,481,015.17** | -192,186,899.64 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **536,481,015.17** | -192,186,899.64 |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** /төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,155,430,545.54** | **1,538,205,955.18** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **39,487,000.00** | **7,645,388.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 39,487,000.00 | 7,645,388.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 39,487,000.00 | 7,645,388.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 39,487,000.00 | 7,645,388.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,115,943,545.54** | **1,530,560,567.18** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 57,367,300.00 | 80,197,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 57,367,300.00 | 80,197,200.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,058,576,245.54 | 1,450,363,367.18 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,058,576,245.54 | 1,450,363,367.18 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,144,865,112.74** | **1,450,110,021.76** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,144,865,112.74** | **1,450,110,021.76** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,142,473,763.74** | **1,444,489,739.70** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 757,151,369.39 | 902,481,416.60 |
| 210101 | Үндсэн цалин | 418,050,774.39 | 481,240,377.17 |
| 210102 | Нэмэгдэл | 270,499,991.00 | 333,760,656.43 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,642,959.00 | 28,835,737.00 |
| 210104 | Урамшуулал | 62,957,645.00 | 58,644,646.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 92,365,612.00 | 114,759,272.91 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 63,086,335.00 | 77,742,483.37 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,293,045.00 | 8,985,433.82 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,807,492.00 | 4,911,502.69 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,593,115.00 | 4,546,931.51 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,585,625.00 | 18,572,921.52 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 53,475,951.00 | 63,116,082.94 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,308,111.00 | 6,085,352.94 |
| 210302 | Түлш, халаалт | 49,167,840.00 | 56,230,730.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 800,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 69198607.00 | 81877600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,187,750.00 | 8,334,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 38,281,057.00 | 39,530,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,138,100.00 | 2,343,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 11,593,500.00 | 16,600,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,998,200.00 | 15,069,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 132,608,945.35 | 202,386,626.25 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 111,561,645.35 | 167,602,826.25 |
| 210502 | Хоол, хүнс | 12,149,800.00 | 25,715,480.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 8,897,500.00 | 9,068,320.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 20,492,000.00 | 48,718,335.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,352,000.00 | 7,724,150.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 6,195,250.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 6,738,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,140,000.00 | 28,060,635.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,800,600.00 | 2,810,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,800,600.00 | 2,810,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,814,479.00 | 6,411,892.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 1,298,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,000,000.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 209,475.00 | 3,781,700.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 35,000.00 | 1,235,192.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 473,000.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 97,004.00 | 97,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11,566,200.00 | 21,928,514.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,566,200.00 | 21,928,514.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,391,349.00** | **5,620,282.06** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 760,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 760,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 2,391,349.00 | 4,860,282.06 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,391,349.00 | 4,860,282.06 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **10,565,432.80** | **88,095,933.42** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **29,690,000.00** | **17,729,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **29,690,000.00** | **17,729,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 29,690,000.00 | 17,729,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 29,690,000.00 | 17,729,900.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-29,690,000.00** | **-17,729,900.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | -19,124,567.20 | 70,366,033.42 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 19,885,067.20 | 760,500.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 760,500.00 | 71,126,533.42 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **247,732,382.97** | **651,337,359.95** | **781,785,435.76** | 1,680,855,178.68 |
| D01 | **2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **247,732,382.97** | **651,337,359.95** | **781,785,435.76** | 1,680,855,178.68 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | -258,000.00 | -258,000.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **247,732,382.97** | **651,337,359.95** | **781,527,435.76** | 1,680,597,178.68 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -191,478,899.64 | -191,478,899.64 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **247,732,382.97** | **651,337,359.95** | **590,048,536.12** | 1,489,118,279.04 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** / төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | хувь |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,646,248,200.00 | 1,462,979,639.70 | 183,268,560.3 | 88.9 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,646,248,200.00 | 1,462,979,639.70 | 183,268,560.3 | 88.9 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,645,487,700.00 | 1,462,219,639.70 | 183,268,060.3 | 88.9 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,010,531,900.00 | 902,481,416.60 | 108,050,483.4 | 89.3 |
| 210101 | Үндсэн цалин | 524,936,600.00 | 481,240,377.17 | 43,696,222.8 | 91.7 |
| 210102 | Нэмэгдэл | 380,610,100.00 | 333,760,656.43 | 46,849,443.6 | 87.7 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 33,662,600.00 | 28,835,737.00 | 4,826,863.0 | 85.7 |
| 210104 | Урамшуулал | 71,322,600.00 | 58,644,646.00 | 12,677,954.0 | 82.2 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 125,994,700.00 | 114,759,272.91 | 11,235,427.1 | 91.1 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 84,852,500.00 | 77,742,483.37 | 7,110,016.6 | 91.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,285,500.00 | 8,985,433.82 | 1,300,066.2 | 87.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,142,800.00 | 4,911,502.69 | 231,297.3 | 95.5 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,142,800.00 | 4,546,931.51 | 595,868.5 | 88.4 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,571,100.00 | 18,572,921.52 | 1,998,178.5 | 90.3 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 65,197,200.00 | 63,116,082.94 | 2,081,117.1 | 96.8 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,500,000.00 | 6,085,352.94 | 414,647.1 | 93.6 |
| 210302 | Түлш, халаалт | 58,097,200.00 | 56,230,730.00 | 1,866,470.0 | 96.8 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 600,000.00 | 800,000.00 | -200,000.0 | 133.3 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 103,240,300.00 | 81,877,600.00 | 21,362,700.0 | 79.3 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,703,100.00 | 8,334,600.00 | 368,500.0 | 95.8 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 60,414,400.00 | 39,530,400.00 | 20,884,000.0 | 65.4 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,347,200.00 | 2,343,000.00 | 4,200.0 | 99.8 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 16,655,600.00 | 16,600,600.00 | 55,000.0 | 99.7 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 15,120,000.00 | 15,069,000.00 | 51,000.0 | 99.7 |
| **2105** | **Нормативт зардал** | 229,736,200.00 | 202,386,626.25 | 27,349,573.8 | 88.1 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 192,316,200.00 | 167,602,826.25 | 24,713,373.8 | 87.1 |
| 210502 | Хоол, хүнс | 25,720,000.00 | 25,715,480.00 | 4,520.0 | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 11,700,000.00 | 9,068,320.00 | 2,631,680.0 | 77.5 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 71,149,000.00 | 66,448,235.00 | 4,700,765.0 | 93.4 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 21,977,000.00 | 20,334,050.00 | 1,642,950.0 | 92.5 |
| 210602 | Тавилга | 12,000,000.00 | 11,315,250.00 | 684,750.0 | 94.3 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 8,672,000.00 | 6,738,300.00 | 1,933,700.0 | 77.7 |
| 210604 | Урсгал засвар | 28,500,000.00 | 28,060,635.00 | 439,365.0 | 98.5 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,580,400.00 | 2,810,000.00 | 770,400.0 | 78.5 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,580,400.00 | 2,810,000.00 | 770,400.0 | 78.5 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,503,000.00 | 6,411,892.00 | 5,091,108.0 | 55.7 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,078,000.00 | 1,298,000.00 | 3,780,000.0 | 25.6 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 625,000.00 | 00.00 | 625,000.0 | 0.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,445,000.00 | 3,781,700.00 | -336,700.0 | 109.8 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,778,000.00 | 1,235,192.00 | 542,808.0 | 69.5 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 480,000.00 | 00.00 | 480,000.0 | 0.0 |
| 210807 | Газрын төлбөр | 97,000.00 | 97,000.00 | 0.0 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 24555000.00 | 21928514.00 | 2,626,486.0 | 89.3 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,555,000.00 | 21,928,514.00 | 2,626,486.0 | 89.3 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 760500.00 | 760000.00 | 500.0 | 99.9 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 760,500.00 | 760,000.00 | 500.0 | 99.9 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 760,500.00 | 760,000.00 | 500.0 | 99.9 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,646,248,200.00 | 1,533,345,673.12 | 112,902,526.9 | 93.1 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 80,197,200.00 | 75,336,917.94 | 4,860,282.1 | 93.9 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 80,197,200.00 | 75,336,917.94 | 4,860,282.1 | 93.9 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,563,275,100.00 | 1,450,363,367.18 | 112,911,732.8 | 92.8 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,563,275,100.00 | 1,450,363,367.18 | 112,911,732.8 | 92.8 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 2,775,900.00 | 7,645,388.00 | -4,869,488.0 | 275.4 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,015,400.00 | 7,645,388.00 | -5,629,988.0 | 379.3 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 760,500.00 | 00.00 | 760,500.0 | 0.0 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 760,500.00 | -760,500.0 | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 71,126,533.42 | -71,126,533.4 | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 26 | 26 | 0.0 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0.0 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 19 | 19 | 0.0 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 6 | 6 | 0.0 | 100.0 |

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 354.0 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Санхүүгийн тайланд тусгагдсан оны эхний үлдэгдлээр байгаа байгууллагад өгөх өглөгийн үлдэгдэл 354.0 мянган төгрөгийг тайлант оны зардал руу бичсэнийг өмнөх оны үр дүн рүү бичиж санхүүгийн тайланд залруулсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4[2], 4 дүгээр зүйлийн 4.1.1[3], УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,
[2] Үнэн зөв байх
[3] Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө

Аудитаар нийт 6,477.2 мянган төгрөгийн нэг зөрчил[4] илэрсэнд 6,477.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, цаашид давтан гаргахгүй байх зөрчлийг арилгах нэг албан шаардлага өгсөн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 6,477.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,009.7 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### 3.1 Албан шаардлага

5.1.1 Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй (3 төрлийн) 21,729.0 м2 газрын мэдээллийг газар эзэмших эрхийн гэрчилгээ болон газрын цахим (egazar.gov.mn) сантай тулган шалгахад үндсэн хөрөнгийн бүртгэлээс 12,029.0 м2-р бага зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", УСОУНББ 17 – Үндсэн хөрөнгө 17.12-т Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Байгууллагын нэр дээр бүртгэлтэй газрын хэмжээг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай тулган баталгаажуулж нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгах

### 3.2 Төлбөрийн акт

1. Галуут сумын ИТХ-ын хуралдааны 2024 оны 12 сарын 26-ны өдрийн 03/05 дугаар тогтоолоор насанд хүрэгчдийн шүдний үзлэг эмчилгээ, амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоосон бөгөөд үүний дагуу сумын эрүүл мэндийн төвийн даргын 2025.01.17-ны өдрийн А/06 дугаар тушаалаар "Анхан шатны амбулаторийн шүдний тусламж үйлчилгээ үзүүлэх журмыг баталсан байна. Тус журмын 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт эмчилгээний төлбөрийг нярвын дансанд төвлөрүүлэхээр зааж нярвын дансанд 5,595.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банканд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ." гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Нярвын дансанд төвлөрүүлсэн 5,595.0 мянган төгрөгийг байгууллагын дансанд төвлөрүүлэх төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Сар бүрийн эмийн захиалгын хуудасны түүврийг эм боох материалын тайлангийн зарлагатай тулган шалгахад нягтлан бодогч захилгын хуудаснаас 882.2 мянган төгрөгийн илүү зарлага гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан

---

[4] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;",гэсэн заалтыг зөрчсөн байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>* Эмийн захилгын хуудасны түүврээс илүү зарлага гаргасан 882.2 мянган төгрөгийг нягтлан бодогчоор төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй (3 төрлийн) 21,729.0 м2 газрын мэдээллийг газар эзэмших эрхийн гэрчилгээ болон газрын цахим (egazar.gov.mn) сантай тулган шалгахад үндсэн хөрөнгийн бүртгэлээс 12,029.0 м2-р бага зөрүүтэй байна. | 1 | - | | | 1 | - | | |
| Шүдний эмчилгээний төлбөрийг нярвын дансанд төвлөрүүлсэн байна. | 1 | 5,595.0 | 1 | 5,595.0 | | | | |
| Сар бүрийн эмийн захилгын хуудасны түүврийг эм боох материалын тайлангийн зарлагатай тулган шалгахад нягтлан бодогч захилгын хуудаснаас илүү 882.2 мянган төгрөгийг илүү зарлага гаргасан байна. | 1 | 882.2 | 1 | 882.2 | | | | |
| **Нийт дүн** | **3** | **6,477.2** | **2** | **6,477.2** | **1** | **-** | | |

------------oOo-------------